

МОНГОЛЫН ОРОН НУТГИЙН МЭДЭЭ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

Далын Ахлагч Жошуа Субандриео

Би томилогдсон салбар, дүүргүүдэдээ зочлох үедээ гэгээнтнүүдийн гэрэлтсэн царай, тэдний зарлигуудад дуулгавартай мөн Их Эзэний гэрээнүүдэд үнэнч байдлыг нь хардаг. Тэдэнд саад бэрхшээлүүд тулгардаг гэдгийг би мэднэ. Зарим нь маш хүнд бэрхшээлүүд ч байдаг. Гэхдээ тэд хүчтэй мөн итгэлтэй байдаг. Тэгээд би оюун санаандаа: Тэдний итгэл, сүсэг бишрэл нь Аврагчид хөрвөгдсөн байдлыг хэрхэн илтгэж байна вэ? Бид Есүс Христийн сайн мэдээнд хөрвөгдсөний дараа ямар адислалууд хүлээн авдаг вэ? Бид бүрэн хөрвөгдөхийн тулд юу хийх ёстой вэ? гэдгийг тунгаан бодлоо.

Би сургалтынхаа үеэр Ерөнхийлөгч Марион Ж.Ромнигийн (1897-1988) хөрвөлтийн талаар Ахлагч Ричард Г.Скоттын эш татсан дараах үгийг уншсан юм. “Хөрвөгдөнө гэдэг нь нэг итгэлээс эсвэл үйлдлийн нэг чиглэлээс нөгөө рүү эргэх гэсэн утгатай бөгөөд хөрвөлт нь сүнсний мөн зан төлөвийн өөрчлөлт юм. Хөрвөгдөнө гэдэг нь Есүсийг болон түүний сургаалыг оюун ухаандаа хүлээн зөвшөөрөхөөс гадна түүнд болон түүний сайн мэдээнд итгэх итгэлээ өсгөх гэсэн утгыг агуулдаг. Итгэл нь өөрчлөлтөөр ажилладаг ба амьдралын утга учрын талаарх ойлголтын бодит өөрчлөлтийг авчирдаг бөгөөд сонирхол, бодол, биеэ авч явах байдлаараа Бурханд үнэнч байх явдал юм. Үнэхээр бүрэн хөрвөгдсөн нэгэн нь Есүс Христийн сайн мэдээний эсрэг зүйлүүдийг хийх хүслүүдээ орхидог. Мөн Бурханы хайр хийгээд

түүний зарлигуудыг дагах шийдэмгий байдлаа хянах юм.”

Хөрвөлтийн агуу жишээнүүдийн нэг залуу Алмагийн талаар Мормоны номонд ийнхүү бичсэн байдаг: “Мөн эдүгээ улиран тохиох дор тэрээр Бурханы сүмийг устгахаар явж байхад нь, тодруулбал тэр [Алма] Мозаягийн хөвгүүдтэй сүмийг устгахыг, мөн Их Эзэний хүмүүсийг буруу замд удирдахыг эрэлхийлэн, Бурханы, эсвээс бүр хааны зарлигуудын эсрэг нууцаар явдаг байлаа. Мөн эдүгээ Алма болон түүнтэй хамт байсан тэд газарт унав, учир нь тэдний сүрдэн гайхсан нь асар их байв; учир нь Их Эзэний тэнгэр элчийг тэд нүдээрээ харсан болой; мөн түүний дуу газрыг доргиох аянга лугаа адил байв; мөн Бурханы хүчнээс өөр юу ч газрыг доргион мөн хоёр тийш болон хуваагдах мэт чичиргэж чадахгүйг тэд мэдсэн бөлгөө. Мөн эдүгээ Алмагийн сүрдэн гайхширсан нь маш их байсан учир тэрээр хэлгүй болов, амаа ч нээж чадахгүй байлаа; тийм ээ, тэрээр доройтон бүр гараа ч хөдөлгөж чадахгүй болжээ; тиймийн тул тэрээр түүн лугаа адил байсан тэднээр өргөгдөж, мөн арчаагүйгээр зөөгдөн, бүр эцгийнхээ өмнө хэвтүүлэгдэх хүртлээ буюу” (Мозая 27:10, 18-19).

Бошиглогч Алма, хүүд нь юу тохиолдсоныг хараад санваартнуудыг мацаг барьж, залбирахыг хүсчээ. Хоёр хоногийн дараа залуу Алмагийн хүч нь сэргэж, тэрээр бооод мөн ярьж эхлэв: “Би нүглүүдээ наманчилсан, мөн Их Эзэнээр гэтэлгэгдсэн; болгоогтун би Сүнсээр



Далын Ахлагч Жошуа Субандриео

төрлөө гэв. Миний бодгаль шаналлын гүн болон алдсын хүлээснээс гэтэлгэгдлээ. Би хамгийн харанхуй ангальд байсан; харин эдүгээ би Бурханы гайхамшигт гэрлийг харнам. Бодгаль минь мөнхийн зовлонд тарчилж байв; гэвч би шүүрэгдлээ, мөн бодгаль минь цаашид дахин өвдөх нь үгүй” (Мозая 27:23-24, 29).

Бидний цөөхөн нь залуу Алмагийн адил маш богинохон, гүн гүнзгий хөрвөлтийн үйл явцыг мэдэрсэн байж болох юм. Гэвч бидний олонх нь өөрсдийн итгэл, гэрчлэлээрээ зүрх сэтгэлийн хөрвөлтийг илүү алгуур, нарийн арга замаар хүлээн авдаг билээ. Хэдий тийм ч үр дүн нь залуу Алмагийн хөрвөлт шиг бодит мөн хүчтэй байдаг.

Наманчлал нь Бурханы сүнсээр дамжуулан гэтэлгэл болон дахин төрөлтийг авчирдаг билээ.

Алмагийн хөрвөлт түүний амьдралд баяр баясгалан, аз жаргалыг авчирсан юм. Бошиглогч Иосеф Смит заахдаа: “Аз жаргал нь бидний амьдралын зорилго мөн загвар юм; мөн хэрэв бид үүн рүү удирдах замыг дагавал төгсгөлд нь аз жаргал байх болно; мөн энэ зам нь ариун журам, шударга байдал, итгэлтэй байдал, ариун байдал болон Бурханы бүх зарлигуудыг дагах юм.”

Би хэдэн сарын өмнө нэгэн дүүргийн чуулганд оролцсон юм. Сургалтынхаа үеэр бидний ярилцсан асуудлуудын нэг нь “Бурханы сүнс-тэй байгаа үедээ бид зүрх сэтгэлдээ юу мэдэрдэг вэ?” гэсэн асуулт байв. Чуулганы яг дараахан, би тэр асуултын хариултыг бичсэн и-мэйлийг орон нутгийн ахмад номлогчоос хүлээн авсан юм:

- Бид гол төлөв баяр баясгалан болон цэвэр ариуныг мэдэрдэг
- Гэрлээр дүүрэн байдаг
- Бидний оюун санаа цэвэр байдаг
- Бид Их Эзэнийг болон бусдыг хайрлах хайрыг мэдэрдэг
- Өгөөмөр сэтгэлийг мэдэрдэг
- Биднийг хэн ч гомдоож чаддаггүй
- Бид маш уучламтгай мөн эелдэг байдаг
- Хийж байгаа зүйлдээ итгэлтэй байдаг
- Бидний хийж байгаа зүйлийг бусад хүмүүс харж байгаа эсэх нь бидэнд хамаагүй байдаг
- Бид гэр бүлийн гишүүдтэйгээ хамт байхыг хүсдэг
- Бид бусдад баяр баясгалантай байхад нь туслахыг мөн Их Эзэний сайн мэдээг хуваалцахыг хүсдэг
- Бид бусдын амжилтанд баяртай байдаг
- Бид Сүмийн ажил болон дуудлагуудаа хийх дуртай байдаг.

- Бид залбирч мөн судруудаас суралцдаг
- Бид Их Эзэний бүх зарлигуудыг дагахыг хүсдэг
- Бид дур сонирхол болон сэтгэл хөдлөлөө хянаж, тайван байж, яриагаа цэгнэдэг
- Бид бусдын талаар сайн зүйлийг ярьж мөн боддог
- Бид бусдыг асуудалтай тулгарах үед нь санаа зовж мөн чин сэтгэлээсээ тэдэнд туслахыг хүсдэг
- Бидний бодол болон үйлдлүүд Бурханд ил тод байдаг гэдгийг бид мэддэг.

Ерөнхийлөгч Угдорф бидэнд заахдаа: “Бид бодол болон үйлсээ Бурханы үгэнд нийцүүлснээр Тэнгэрлэг Эцэгээ хайрлах хайраа өсгөн нэмэгдүүлж мөн илэрхийлдэг юм. Түүний цэвэр хайр нь биднийг илүү цэвэр, ариун болоход чиглүүлэн дэмждэг. Энэ нь биднийг айдас эсвэл хариуцлагаас болж бус харин Түүнд хайртай учраас Түүнтэй илүү адилхан болох чин сэтгэлийн хүслийн улмаас зөв шударга байдалд алхахад урамшуулдаг. Үүгээр бид ‘дахин төрж мөн цусаар бүр [тэр] миний Төрсөн Ганцын цусаар . . . цэвэршигдэж, бүх нүглээсээ ариусагдаж . . . , мөн энэ дэлхийд мөнх амьдралын үгсийг мөн ирэх дэлхийд бүр үхэшгүй байдлын алдар сууд мөнх амьдралыг та нар [бид нар] эдэлж болно’ (Мосе 6:59). Хайрт ах, эгч нар минь, хэрэв та нар алдаа гаргасан бол итгэлээ бүү алдаарай. Хэрэв та нар Христийн шавь байхуйц зохистой байдлыг бүх үед мэдрэхгүй бол бүү сэтгэлээр унаж, цөхрөөрэй. Зөв шударга байдалд алхах хамгийн эхний шат бол энгийнээр туршиж үзэх юм. Бид заавал туршиж үзэх ёстой . . .”

Энэхүү Улаан өндөгний баяр нь бидэнд Голготагийн загалмай дээр амиа өгч, бүх гүниг, өвдөлт, зовлон шаналал болон үхлийг мэдэрсэн Эзэнийхээ талаар тунгаан бодохыг сануулдаг. Энэ үйл явдал нь өмнөх орой нь Тэнгэрлэг Эцэгээ болон бүх хүмүүнийг хайрлах хайр мөн хүн төрөлхтний аврал ба гэтэлгэлийн төлөөх Гетсемани дахь Түүний залбирлын дараа болсон юм. Тэр гурав дахь өдрөө дахин амилсан билээ. Тэрээр нүгэл болон үхлийг ялан дийлсэн. Энэ нь бүх хүн төрөлхтөнд ямар агуу найдвар өгдөг билээ! Энэ нь бидэнд үхэшгүй байдлыг хүлээн авах боломжийг олгодог бөгөөд хэрэв бид зохистой байж, эцсээ хүртэл тэвчих юм бол мөнх амьдралыг өвлөх болно.

Энэ мөнх бус амьдралдаа бүх саад бэрхшээлүүдийг үл харгалзан хамгийн сайнаараа хичээн амьдарцгаая. Их Эзэндээ зүрх сэтгэл болон үйлс үйлдлээрээ гүн гүнзгий хөрвөгдөцгөө. Цагаатгалаар дамжуулан тэр бидэнд найдвар болон үүрдийн амьдралд хүрэх замыг өгсөн юм. Би Их Эзэн дэх хөрвөлт нь илүү гүн гүнзгий байх тусам бидэнд байх Түүний Сүнс нь илүү хүчтэй байж, эцэст нь биднийг аз жаргал руу хөтөлдөг гэдгийг гэрчилж байна.

Энэ сударт Их Эзэн баттай тайтгарлыг өгдөг: “Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай” (Иохан 14:27).

Тэр амьд мөн бидэнд хайртай гэдгийг би мэднэ. Би энэхүү гэрчлэлийг Есүс Христийн ариун нэрээр хуваалцаж байна, Амен. ■

ОРОН НУТАГТ БОЛЖ БУЙ ҮЙЛ ЯВДЛУУД

Орон нутгийн редактор Н.Пүрэвсүрэн

Бид баптисм хүртэж, Бурхантай гэрээнд орохдоо Түүний хүүхдүүдэд үйлчилж, Христийн сайн мэдээг бусдад заан түгээж, номлох гэрээг байгуулдаг. Мормоны номын бошиглогч Лихай амьдралын модны жимснээс хүртээд тэр даруйдаа өөрийн гэр бүлийнхнийгээ бодож, тэдэнд мөн амсуулахыг хүсдэг. Яг үүнтэй адил бид бүхэн ч анх баптисм хүртэх тэр мөчид Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ хүлээн авч, Түүний сайн мэдээний дагуу амьдран, тэдгээрийг Бурханы хүүхдүүдэд түгээх хүсэл эрмэлзлээр дүүрч, Ариун Сүнийг хүчтэйгээр мэдэрдэг. Бид хэрхэн Түүний сайн дагалдагчид болох вэ? Бид хэрхэн Түүний хүүхдүүдэд үйлчлэх вэ? Үүнийг гүйцэлдүүлэх гайхамшигтай аргуудын нэг нь бүрэн цагийн номлолд үйлчлэх, өөрсдийн хүүхдүүдийг түүнд бэлтгэх, Сүмийн залуусыг үйлчлэхээр урамшуулан дэмжих явдал мөн. Монголд Сүм байгуулагдснаас хойших энэ хорин жилийн турш Монголоос нийт 1000 гаруй залуус АНУ, Англи, Солонгос, Япон, Чех, Оросын Холбооны Улс, Монгол зэрэг дэлхийн олон улс орнуудад бүрэн цагийн номлолд үйлчилжээ. Одоо ч олон залуучууд номлолд гарахаар бэлтгэж байна. Өнгөрсөн 10-р сарын Ерөнхий

Чуулганаар Бошиглогч Томас С.Монсон гайхамшигтай илчлэлтийг гишүүдэд мэдээлж, залуу эрэгтэйчүүд 18 наснаасаа, залуу эмэгтэйчүүд 19 наснаасаа бүрэн цагийн номлолд үйлчлэх болсныг зарласнаас хойш номлолд үйлчлэхийг хүсэгчдийн тоо эрс нэмэгджээ. Энэ бол Их Эзэний агуу ажил бөгөөд энэ ажилд Сүмийн бүх насны гишүүд хамрагдах боломжтой. Мөн Сүмд олон төрлийн номлолын үйлчлэл байдаг бөгөөд насанд хүрсэн бүх гишүүд гэрээсээ Сүмийн үйлчлэлийн номлол, гэр бүлийн түүхийн болон нэрс индексжүүлэх үйлчлэлийг гэрийнхээ компьютер дээрээс хийх мөн ахмад номлогчоор үйлчлэх боломжтой байдаг. Эдгээр номлолын ажлуудын талаар та бүхэн сүмийн албан ёсны сайт болох ldschurch.org болоод өөрсдийн салбарын ерөнхийлөгч ба дүүргийн ерөнхийлөгч, гадасны ерөнхийлөгч ба тойргийнхоо бишоп нартай уулзан, мэдээллийг авч болно. Энэ талаар Сүмийн гарын авлага 1 дээр тодорхой заасан байдаг. Сэлбэ тойргийн гишүүн Н.Пүрэвсүрэн эгч Сүмийн үйлчлэлийн номлолд 2012 оны 7 сараас 2013 оны 1 сарыг хүртэл 6 сар Номлолын алба ба Мөрөн салбарт үйлчилж, амжилттай өндөрлөлөө. Тэр өмнө нь 2006–2008

онд бүрэн цагийн ахмад номлогчоор Английн Манчестер Номлолд дуудагдан 10 сар үйлчилсэн. Номлолд байхад нь Финляндын Хельсинкийн Ариун Сүм нээгдэж, орос англи хэлтэй ахмад номлогчийн шаардлага гарах үед Их Эзэний дуудлагаар Хельсинкийн Ариун Сүмийн номлогчоор шилжин үйлчилж, бүрэн цагийн номлолын ажлаа Ариун Сүмийн номлолын үйлчлэлээр дуусгасан билээ. Тиймээс Сүмийн үйлчлэлийн номлол болоод ахмад номлогчоор хэрхэн үйлчилж болох талаар мэдэхийг хүсч байгаа монголын сүмийн олон гишүүнтэй өөрийн туршлагаас хуваалцахын ялдамд Бурханы ариун үйлсэд сэтгэл шулуудан үйлчлэхийг та бүхэнд уриалж байна. Бурханы хүүхдүүдэд олон янзын номлолоор дамжуулан үйлчилснээр бид Түүний агуу адислалуудыг хүлээн авах болно. Сүмийн үйлчлэлийн номлолыг: Сүмийн үйлчлэлийн алба, гэр бүлийн түүх, номлолын алба, тойрог ба салбар, дүүрэг ба гадас дээрээ төрөл бүрийн нэгж хэсгүүдэд таны чадвар болоод санваарын дуудлагын дагуу хийж болно. Үүнийг эхлэхийн тулд өөрийн салбарын ерөнхийлөгч юм уу бишоптой ярилцлаганд орж, дараа нь дүүрэг буюу гадасны ерөнхийлөгчтэй ярилцлаганд ороод тэд таны үйлчлэх албыг таны хүсэлтийн дагуу шийдэж эсвэл томилж болно. Бүх номлолын дуудлагын адил уг номлолын дуудлагыг Азийн Бүсийн номлолын албанд

зохих санваартан удирдагч мэдэгдэж батлах болно. Үйлчлэлийн номлолын хугацаа нь 6 сараас 24 сарын хугацаатай байж болох бөгөөд гэртээ байж, долоо хоногт доод тал нь 8 цаг дээд тал нь 32 цагийн үйлчлэлийг хийнэ. Үйлчлэлийн номлолын зардлыг тухайн гишүүд өөрсдөө даана. Ахмад номлогчоор үйлчлэхийн тулд таны асрамжинд байгаа хамгийн бага хүүхэд 18 нас хүрсэн байх шаардлагатай бөгөөд танаас хамаарах гэр бүлийн гишүүн байхгүй өөрөө номлолын зардлаа бүрэн даах чадвартай байх ёстой. Өмнө нь ганц бие ахмад номлогчид залуу номлогчдын адил сарын 400 ам. долларын төлбөрийг хийн үйлчлэх боломжтой байсан боловч 2008 оноос Сүмийн удирдлагаас шинэ мэдэгдэл гарч, зардлыг өөрсдөө бүрэн хариуцахаар болсон билээ. Тиймээс ахмад номлогчоор үйлчлэхийг хүсч байгаа гэр бүлийн хос болоод бага хүүхэд нь 18 нас хүрсэн ганц бие эгч нар эртнээс зорилготойгоор сангаа бүрдүүлж, Их Эзэний агуу ажилд өөрсдийн цаг зав, мэдлэг чадвараа зориулахыг хүсье. Ертөнцөд бид саад бэрхшээл, сорилтуудаар дамжуулан өсөн хөгжиж, агуу мэдлэгийг олж, дэлхийн зүйлд бус Христийн сайн мэдээний мэдлэгт сүнс­лэгээр хөгжин, Их Эзэнийхээ оршихуйд Түүнтэй мөнхөд амьдрах эрхийг олохоор ирсэн билээ. Энэ бол бидний зорилго мөн. ■

Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Түүхээс

Улаанбаатар Баруун Гадасны түүхч А.Тунгалаг

2001.01.14 Улаанбаатар хойд дүүргийн хамгийн анхны Сонгино салбарын чуулган чуулж, дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл тэргүүлж, сүнс­лэг яриа өгч, гэрчлэлээ хуваалцсан байна.

2001.02 сар Монгол хэл дээр хөрвүүлэгдсэн “Мормоны Ном” Халх Монгол хэвлэлийн газар хэвлэлтэнд өрөгдөж эхэлжээ.

2001.02.01-04 Нийслэлийн Баянзүрх дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт Сүмийн Баянзүрх байрны барилгын ажил эхэлж, суурийн бетон цутгалтын бэлтгэл ажил эхэлжээ.

2001.02.05 Хонг-Конгоос Сүмийн барилгын инженер мэргэжилтэн нар ирж арматурын угсралтыг үзэж шалгаад бетон цутгах ажилд оролцжээ.

2001.02.17-18 ба 2001.03.03-04 Улаанбаатар хойд дүүргийн Бага хурал Сентоза байр болон Чингис зочид буудлын хурлын танхимд болж харин орон нутаг дахь Шинэ Дархан, Хуучин Дархан, Эрдэнэт, Сүхбаатар болон Зүүн Хараа салбарууд Дарханы шинэ байранд хуралджээ. Чуулганыг Номлолын Ерөнхийлөгч Глен Харлан Кларк тэргүүлж, Хойд дүүргийн ерөнхийлөгч Д.Ганболд ах удирдав.

2001.03.17 Улаанбаатар хойд дүүрэг НХБүлгийн 159 жилийн ойг тэмдэглэсэн байна. Хөдөө орон нутгийн салбарууд хоёр-дугаар сард тэмдэглэжээ.

2001.06.20 Аароны санваар дахин сэргээгдсэний ойд зориулж “Эцэг ба хүүгийн өдөрлөг” Дархан хотын Хараа голын дэргэд болж, Зүүн Хараа, Сэлэнгэ, Шинэ Дархан, Хуучин Дархан, Эрдэнэт салбаруудын аарон болон мелкизедек санваартан эцэг ба хөвгүүд, сүмийн гишүүн бус аав нар уригдан оролцжээ.

2001.10.18 Мормоны Ном Монгол хэлээр албан ёсоор хэвлэгдэв.

2001.11 сар Монгол хэлээр хэвлэгдсэн Мормоны Ном Сүмийн гишүүдийн гар дээр ирлээ. Анхны батлагдсан Дууны ном монгол хэлээр хэвлэгдэн, Ариун ёслолын дуунууд эх хэл дээр дуулагдаж байна. Сургаал ба Гэрээ болон Агуу Үнэт Сувд номын орчуулга хийгдэж эхэлжээ.

2001.11.30 Сүмийн Ерөнхий Чуулганыг видео бичлэгээр бүх салбарын гишүүдэд анх үзүүлжээ.

2002 он ЕХХҮГСүмийн “Дезерет” ОУЭБайгууллага нь Монгол Улсын хүн ардын боловсрол, амьдрал ахуй, эрүүл энхийн төлөөх тусламжийн олон төсөл хэрэгжүүлж ирсэн

билээ. Бүтэлттэй төрсөн нярай хүүхдийн амь насыг аврах орчин үеийн техник эзэмших арга зүйн сургалтыг эмч, сувилагч болон хүүхдэд анхаарал халамж тавьдаг бусад хүмүүст явуулжээ. Сургалтын шинэ арга, заалтууд үр дүнгээ үзүүлж, нярай хүүхдийн эндэгдэл үлэмж хэмжээгээр буурчээ.

2002 онд Сүм нь хоёр дүүрэг, 21 салбарын 4356 гишүүнтэй болжээ. Монголын 89 Ахлагч, 73 эгч дэлхий дахинаа бүрэн цагийн номлолд үйлчилсэн байна.

2003.03.09 Хоёр дүүргийн хамтарсан семинарын 14-17 насны хүүхдүүд мөн эцэг эхчүүд, сонирхогч нарт зориулсан Галын дэргэдэх ярилцлагыг анх удаа зохион байгуулжээ.

2003.05.23 Азийн Бүсийн Ерөнхийлөгч Жон Б.Диксон Налайх дахь Сүмийн байрыг онцгойлон адисалжээ.

2003.06 сар Ази дахь ЕХХҮГСүмийн энэрийн байгууллагаар санхүүжигдсэн шинэ худаг өнчин хүүхдүүдэд зориулсан сургууль нээх боломж олгожээ.

2003.06.23-28 Өсвөр үеийнхний анхны чуулга уулзалт гурван өдөр болж хот, орон нутгаас 800 гаруй хүүхэд, залуус оролцож, сургаалын талаар өөрсдийн гэрчлэлээ хуваалцаж, бие биенээсээ суралцсан сүнслэг уулзалт болжээ.

2003.06.29 Монголын УБ Номлолын анхны Ерөнхийлөгч Ричард Е.Кук ах, Мэри Н.Кук эгч болон ахмад

номлогч байсан Чарльз Харди ах, Жин Харди эгч нар галын дэргэдэх ярилцлага зохион байгуулж, сүнслэг яриа, үнэтэй сургамжаар монгол гишүүддээ хайраа үзүүлжээ.

2003.07.20 Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүн Ахлагч Аллен Д.Андерсен, Жаннет Андерсен эгч болон Данни Чин ах нар “Мөнхийн холболт”, “Ургийн бичиг”, “Нас барагсдыг аврах” сэдвээр үг хэлсэн байна.

2003.09.11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэргэнцэр тараах ажиллагаа нийслэл хот, хөдөө орон нутаг даяар явагдаж, Сүмийн хүмүүнлэгийн байгууллагаар дамжуулан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцэрийн сан”-гаас ирсэн 500 ширхэг тэргэнцэр очсон хүн бүрт ачлал болж амьдралд нь баяр баясгалан нэмжээ.

2003.10 сар Сургаал ба Гэрээ Судрын орчуулгын ажлыг дуусгаж, хяналтанд оруулжээ.

2003.11.30 Ахмад номлогч Ивон Хьюбли эгчийн найруулсан “Их Эзэний Гар” хөгжмийн хөтөлбөрт тоглолтыг монгол хэл дээр Ц.Ариунаа эгч орчуулан, Н.Пүрэвсүрэн эгч зохион байгуулан, дуу хөгжмийг А.Бүтэд эгч найруулжээ. Хьюбли эгч хөтөлбөрийг анх Австралид англи хэлээр найруулан тоглож, Америкт Христийн мэндэлсний баярын тоглолт дээр өөрөө хүүрнэгчийн үүрэг гүйцэтгэдэг байсан ба Монгол хэл дээр Н.Пүрэвсүрэн эгч уншив.

2003.12 сар Айдохогийн Престоны гэр бүлийн хос Майк Гарвис, Муриел Гарвис нар Монголын эмнэлгүүд дэх рентген туяаны аппаратуудыг тохируулах болон засварлах сургалт явуулж тусламж үзүүлэх хэрэгцээг тодорхойлох Сүмийн дуудлага хүлээн авч ажиллахаар иржээ. Тэд Скаутыг дэмжигчдийн хувьд өөрсдийн найз нөхөд, хөршүүдийнхээ бэлэглэсэн скаутын ном, товхимлуудыг Монголын ХҮТэгээнтэн цорын ганц Скаутмастер Н.Адъяаболд ахад хүлээлгэн өгсөн нь Скаутын Хөдөлгөөнийхөнд үнэтэй дэмжлэг үзүүлсэн сайхан бэлэг болсон байна.

2003.12.20-25 Хоёр дүүргийн хот, орон нутаг дахь салбарууд Христийн мэндэлсний баяр тэмдэглэжээ.

2003.12.31 Монголын хоёр дүүргийн 21 салбар нэгжид АНУ-аас 48, Монгол Улсаас 47 нийт 95 бүрэн цагийн номлогч үйлчилжээ. Ахмад номлогчид болох АНУ-ын 11 гэр бүлийн хос Монголын Номлолд үйлчилсэн байна. Гишүүнчлэлийн тоо 5300-д хүрчээ.

2003 онд Улаанбаатар хойд дүүргээс 26, Улаанбаатар дүүргээс 47 номлогчид Монгол, АНУ, Орос, Балтийн тэнгисийн орнууд болон Украины Номлолд үйлчилжээ.

“Дезерет” ОУЭБайгууллагаар дамжуулан олон янзын төслүүд хэрэгжин, монголын эмнэлгүүд, хүүхэд асран хүмүүжүүлэх газар болоод бусад олон газарт хүмүүнлэгийн тусламжийг хүргэжээ.

2004.04.18 Азийн Бүсийн Ерөнхийлөгч Ахлагч Жон Б.Диксон, Монгол Улаанбаатар Номлолын Ерөнхийлөгч Гарри Р.Гиббонс нар удирдан Монгол дахь ЕХХҮГСүмийн удирдлагын бүтцийн зохион байгуулалт хийх Онцгой хурлыг хуралдуулж, шинэ алхам буюу “Гайхамшигт шилжилт”-ийн эхлэлийг тавьсан түүхэн үйл явдал нийслэл Улаанбаатар хотод болов.

Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн шийдвэрээр Улаанбаатар болон Улаанбаатар хойд дүүргүүд өөрчлөгдөн, Улаанбаатар ба Дархан гэсэн хоёр том дүүрэгт шинээр зохион байгуулагдав. Арванхоёр Төлөөлөгчдийн Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл 1993 оны 4-р сарын 15-нд Монгол Улсын уудам цэлгэр газар нутагт Есүс Христийн дахин сэргээсэн сургаалыг түгээх албан ёсны онцгойлон адислалыг өгснөөс хойш эдүгээ 11 жилийн дараа Монголд ЕХХҮГСүм 6000 гаруй гишүүдийг эгнээндээ нэгтгэсэн Номлолын алба ба хоёр дүүргийн 16 үндсэн салбар нэгжийн удирдлагад санваартан монгол ах нар дуудагдан үйлчилж эхэлжээ. Шинэ зохион байгуулалтаар Монгол дахь ЕХХҮГСүмийн Улаанбаатар дүүргийн ерөнхийлөгчөөр Д.Ганболд, Дархан дүүргийн ерөнхийлөгчөөр А.Соронзонболд ах нар томилогдон дэмжигджээ. Мөн Улаанбаатар дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд болох Мелкизедек

санваартан арванхоёр монгол ах нарыг шинээр зохион байгуулагдсан салбарын удирдлагуудын хамт танилцуулжээ. Шинэ зохион байгуулалтаар Улаанбаатар дүүргийн ерөнхийлөгчийн 1-р зөвлөх Б.Тамир, 2-р зөвлөх Амарбат, нарийн бичиг Нямаа, санхүүч М.Батаа нар дуудагдан дэмжигдсэн байна. Дүүргийн зөвлөлийн гишүүдэд Айбек, Бат-Эрдэнэ, Амарсанаа, Балданпүрэв, Т.Энхтүвшин, Ц.Батбаяр, Цэрэндагва, Ш.Хавтгай, Б.Дашдаваа, Батболд, Баатар ах нар дуудагдсан байна.

2004.06 сар Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөл Цэрэнжавын Ариунаа эгчийг Сүмийн “Лиакхона” сэтгүүлийн орон нутгийн мэдээ хариуцсан редакторын үүрэгт ажилд томилжээ.

2004.06.17-19 Монголд анх удаа ЕХХҮГСүмийн “Залуу үе чуулган” болж, эх орныхоо өнцөг булан бүрээс цугласан 485 өсвөр үеийнхэн сүнслэг бөгөөд хөгжилтэй цагийг хамтдаа өнгөрүүлэв.

2004.06.19 Азийн Бүсийн Ерөнхийлөгч Жон Б.Диксон Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт орших ЕХХҮГСүмийн Цуглааны байр болон Номлолын төв, Сүмийн боловсролын систем, Үйлчлэлийн төв зэрэг бусад дагалдах хэсгийн үйл ажиллагааг энэхүү байгууламжид үргэлжлүүлэн явуулахад зориулан онцгойлон адислах цуглааныг ерөнхийлөн удирджээ.

2004.09.07 Сонгино-хайрхан дүүргийн нутаг дэвсгэрт

баригдаж буй Сонгино салбарын Сүмийн барилгын ажил гүйцэтгэлийн шатандаа явагдаж байв.

2004.09.10-12 ЕХХҮГСүмийн Баянзүрх байрны нээлттэй өдөр болсон байна. 3 өдөр үргэлжилсэн уг үйл ажиллагаанд 2000 гаруй хүн оролцсон бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Шашны асуудал эрхэлсэн зөвлөх, Төр засгийн байгууллага, УИХ, ИТХурлын гишүүд болон бусад шашны урсгалын төлөөлөгч болоод олон түмэн хүрэлцэн иржээ. Мөн телевиз, радио, хэвлэл мэдээллийн төлөөлөгчид нээлтийн үйл ажиллагааг орон даяар нийтэд танилцуулсан байна.

2004.09.21. Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй шашны байгууллагууд хуран цугларч, энхтайвны төлөө дуу хоолойгоо нэгтгэн, Монголд болоод дэлхий дахинаа энхтайван үргэлжид оршин тогтнохын төлөөх залбирлыг Сүхбаатарын талбайн өмнөх цэцэрлэгт хүрээлэнд хийцгээж, энх тайвны хонхыг дуугаргасан байна.

2004 он Монголын Гэгээнтэн ах эгч нарын итгэл ба дуулгавартай байдал нь Бурханы агуу адислалаудаар дүүрэн байж, Сүмийн гайхамшигтай сайхан шинэ барилга байгууламжууд сүндэрлэн босоор, Чойбалсан, Эрдэнэт, Сонгино-Хайрхан дүүргийн 6-р хорооны Таван шар хэмээх газарт чанарын өндөр шаардлага хангасан байрууд ашиглалтанд ороход бэлэн болжээ. ■

Дезерет Олон Улсын Энэрлийн Байгууллагын Үйл Ажиллагаанаас

Булган Аймаг Дахь Дотоод Шүүрлийн Булчирхайн Кабинет

Булган Аймгийн Нэгдсэн Эмнэлэг нь одоо дотоод шүүрлийн булчирхайн кабинеттай болсон бөгөөд орон нутгийн нэг эмч тэнд ажиллаж байна. Тэрээр Дезерет Олон Улсын Энэрлийн Байгууллагаас үзүүлсэн хүмүүнлэгийн тусламжинд маш их талархаж байлаа. Тус кабинетын нээлтийн үйл ажиллагаанд Аймгийн Захиргааны Нийгмийн Бодлогын Хэлтсийн Дарга Буянжаргал оролцсон бөгөөд бид Эмнэлгийн дарга Шижирбаатартай уулзаж, санал солилцсон билээ.

“Хөгнө Мээж” ТББ нь манай байгууллагад хүсэлт гаргасны үндсэн дээр Дезеретээс биеийн өөх хэмжигч багаж, хөлний мэдрэмж шалгагч багажны иж бүрдэл, ширээ, сандал, сургалтын үзүүлэн самбар, ном, гарын авлага, өндөр ба жин хэмжигч, мөнгөн устай даралтын аппарат, чагнуур, туузан метр, глюкоз шалгах тесттэй үзлэгийн багажны иж бүрдэл зэргийг хандивласан юм.

Булган аймаг нь Монгол Улсын хойд хэсэгт байрладаг бөгөөд 58,000 орчим хүн амтай. Тус аймагт манай Сүм 50 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж, сайн мэдээнээс суралцаж байна. Эрүүл мэндийн тусламж үзүүлэгч гол байгууллага нь Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг болох 200 гаруй ажилтантай Аймгийн Нэгдсэн Эмнэлэг юм. Саяхныг хүртэл тус эмнэлэгт сургагдсан булчирхайн эмч байгаагүй юм. Чихрийн шижингийн шинж тэмдэг илэрсэн аймгийн иргэд машинаар 1 цаг яваад хүрдэг зэргэлдээх аймаг руу явж шинжилгээ өгч, эмчлүүлдэг бөгөөд эмчилгээний зардлаа өөрсдөө гаргадаг байсан аж. Аймгийн нэгдсэн эмнэлэг булчирхайн сургагдсан эмчтэй болсноор өвчтөнүүд аймагтаа эмчлүүлэх боломжтой болж байгаа юм. 2011 онд тус аймагт 260 гаруй чихрийн шижингийн өвчтэй, 16 харааны сулралтай, 21 бөөрний дутагдалтай, 64 байнгын инсулины эмчилгээ хийлгэх шаардлагатай иргэд бүртгэгсэн байна.

Нээлтийн үйл ажиллагааны дараа тэд 20 өвчтөнг үзэж, шаардлагатай эмчилгээний заавар зөвлөгөөг өгсөн байна. ■



Ахлагч Ричардсон, Ричардсон эгч нар эмнэлгийнхний хамт



Шинжилгээний аппарат



Сургагдсан эмч нар

Залуу насанд хүрэгчдийн халловээн баяр

Буцаж ирсэн номлогчид ба Залуу насанд хүрэгсдийн хорооны зөвлөх Хант эгч

Тал бүрээс аймшгийн биетүүд ирэн сүрлэг байлаа! Майкл Жексоны “Триллер” дууны аянд хэсэг залуу насанд хүрэгсдийн бэлтгэсэн халловээн бүжиг 2012 оны 11-р сарын эхээр боллоо. Бүжигчид төрөл бүрийн дүрст хувирсан хувцсыг өмсөж, нүүр засалт хийлгэсэн нь яг л аймшгийн оронд ирсэн

мэт сэтгэгдлийг хүн бүрт төрүүлж байлаа. Гэхдээ цэнгээнд оролцсон хүн бүрийн сэтгэлийг баясаж, маш их таалагдсан болохоор хэн ч тарахыг хүсэхгүй дахин нэг бүжиглэхийг хүсч байлаа. Уг үйл ажиллагаа залуу насанд хүрэгсдийг улам дотносон нөхөрлөж, нэгдмэл байдлыг нь бататгаж чадсан юм. ■



“Би чамайг дуудаж байна...”

Бид хэн бэ? Таагаарай...



Христийн мэндэлсний баярын сүнслэг уур амьсгалыг дахин мэдрэхүй



Улаанбаатар Баруун гадасны найрал дуучид



Улаанбаатар Баруун гадасны найрал дуучид



Гоцлол дуучин Өнөржаргал, Ерөнхийлөгч Кларк



“Их Эзэний залбирал” Монгол Улсын гавьяат жүжигчин А.Бүтэд



Улаанбаатар Баруун гадасны найрал дуучид



Төгөлдөр хуурч, авьяаслаг хөгжимчин Б.Отгончимэг